



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 343

Улаанбаатар хот

Х.Бадамсүрэнг ажлаас чөлөөлөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 6.2 дахь заалт, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчийн үйлдвэрийн газрын Ерөнхий захиралтай байгуулсан 2019/16/К дугаартай контрактын 5.3.5, 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 27 дугаар тогтоолоор Хоохорын Бадамсүрэнг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Зэс, металлын группийн даргаар томилогдсонтой холбогдуулан “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирлын үүрэгт ажлаас 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлж, түүнтэй байгуулсан контрактыг цуцалсугай.

2.Х.Бадамсүрэнтэй контрактын хүрээнд холбогдох тооцоо хийж, тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ